

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-7
1. “Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаарх Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсох	3-5
2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	5-7

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
04 дүгээр сарын 02-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 52.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 23 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батбаяр, П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Д.Жаргалсайхан, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, Д.Пүрэвдаваа.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа “Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар мэдээлэл, 3 дугаарт байгаа “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлаас 7 хоног хойшлуулах тухай Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас ирүүлсэн хүсэлтийг танилцуулан, хэлэлцэх асуудлын дарааллаас хасаж, хойшлуулах горимын санал гаргав.

С.Ганбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын 2, 3 дугаарт байсан асуудлыг хойшлуулахаар тогтов./15:27/

**Нэг. “Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаарх
Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Автотээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Э.Мөнхсайхан, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Өлзийжаргал, Төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хэсгийн гүйцэтгэгч “Ди Ди Эй Жи” ХХК-ийн захирал Д.Ганзаяа, мөн компанийн төслийн менежер С.Балжинням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар мэдээлэл хийх Засгийн газрын гишүүн хуралдаанд ирээгүй тул уг асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

С.Ганбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул “Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаарх Зам, тээврийн сайдын мэдээллийг хойшлуулав. /15:30/

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Л.Мөнхбаясгалан, Б.Тулга, П.Мөнхтулга, С.Ганбаатар нар үг хэлэв.

С.Ганбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Д.Үүрийнтуяа, Б.Тулга нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдаа.

Уг асуудлыг 15 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 15 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 69.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим, 15 цаг 23 минут*

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. С.Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна. Бадамсүрэн гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна. Бум-Очир гишүүн ирсэн байна. Жангабыл гишүүн 3 дугаар тойрог ирсэн байна. Замира гишүүн ирсэн байна. Мөнхбаясгалан гишүүн 7 дугаар тойрог ирсэн байна. Очирбат гишүүн ирсэн байна. Пунсалмаа гишүүн ирсэн байна. Буяагийн Тулга гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна. Уянга гишүүн ирсэн байна. Үүрийнтуяа гишүүн 4 дүгээр тойрог ирсэн байна. Энхтуяа гишүүн ирсэн байна. Энхцэцэг гишүүн ирсэн байна. Ингээд 1 гишүүн чөлөөтэй, 2 гишүүн чөлөөтэй байгаа. Ингээд өнөөдрийн хуралдааны ирц хүрсэн учраас өнөөдрийн хуралдааныг эхэлснийг мэдэгдье. Нээснийг мэдэгдье.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 4 асуудал байгаа.

“Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаар Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсоно. Ер нь гишүүд бол бас тодорхой Байнгын хороодоор оруулах мэдээлэл сонсох тийм шаардлагууд байгаа бол бас бичгээр бидэнд ханддаг. Энийг бол Батлут гишүүн бас санал тавьсан. Ингээд одоо сонсоно.

2 дугаарт бол Ашигт малтмалын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох.

3 дугаарт “Ажлын хэсэг байгуулах тухай” Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах ийм шийдвэр байгаа. Энэ дээр Замира гишүүн бас гишүүдээс санал ирсэн учраас энийг ярьж байна.

4 дүгээрт “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны нөөцийн зөв зохистой ашиглалт, усны ашиглах боломжит нөөц, ус хэрэглээний хэтийн төлөв, ус ашигласны болон ус бохирдуулсны үнэ, төлбөр, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай саналыг бас Ганзориг гишүүн гаргасан байгаа.

Ингээд энэ 4 хэлэлцэх асуудал байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу.

Хэлэлцэх асуудал дээр нэг горимын санал би гаргая. Гишүүд дэмжинэ үү. Юу гэвэл 2 дахь болон 3 дахь асуудал дээр Ашигт малтмалын тухай хуулийн 42

дугаар зүйлийн хэрэгжилтийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас, яамнаас энэ дээр орон нутгуудаас бас мэдээллүүд дутуу ирээд байна. Бас цаг хугацаа орно. Тодорхой 7 хоногоор хойшлуулж өгөөч ээ гэж хүсэлт гаргасан. Энэ манай гишүүдэд их чухал шүү. Тойрог дээр байгаа, та нарын тойрог дээр байгаа уул уурхай, ашигт малтмалын лицензүүд орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан уу, үгүй юү гэдэг асуудал шүү. 42 дугаар зүйл. Тэнд байгаа аж үйлдвэрлэгч, жижиг, дунд үйлдвэрлэгч, өрхийн аж ахуйнууд тус дэм болж байна уу, үгүй юү гэдэг асуудал. Энэ дээр ийм чухал асуудал дээр нухацтай мэдээллээ дэлгэрэнгүй ярья гэдэг ийм санал яамнаас гаргасан учраас үүнийг Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээлэл сонсох асуудлыг дарааллаас хасаж, хойшлуулах горимын саналыг би гаргаж байна. Та бүхэн бас энэ дээр дэмжиж өгнө үү. Ингээд горимын саналаар санал хураалт хураая. Дэмжиж байгаа нь кнопоо дарна уу. Хэлэлцэх асуудлаасаа хасъя гэдэг санал оруулж байгаа юм. Хойшлуулъя. Шалтгаан нь энэ дээр бас яг Байнгын хороонд мэдээлэх хангалттай мэдээлэл байхгүй байна байна. Орон нутгаас бас мэдээллүүд ирэхгүй байна. Тэгээд урьдчилна гэсэн тийм л шалтгаан шүү. Ингээд дарааллаас хасаж, хойшлуулах гэсэн томъёоллоор дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. Саналыг 84,6 хувиар зөвшөөрч, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хүсэлтийн дагуу тус сайдын мэдээллийг сонсох асуудлыг дарааллаас хасах горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан хойшлууллаа. Ажлын хэсэг энийг чамбайруулж, дараагийн хурлаар оруулж ирэх чиглэл өгье. Ингээд үүнтэй холбогдуулаад бас ажлын хэсэг байгуулах 3 дугаар саналыг бас дарааллаас хасаж байгааг мэдэгдье.

Ингээд хэлэлцэх асуудал 2 боллоо.

Хэлэлцэх асуудлын эхэнд “Эрдэнэт машин” цогцолборын үйлдвэр байгуулах төслийн талаар Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсоно.

Байнгын хорооны хуралдааныг хүндэтгэж сайд орж ирэх ёстой шүү. Сайд орж ирэх ёстой шүү. Ингээд Зам, тээврийн сайд хаана байна. Байнгын хорооны хурлыг хүндэтгэнэ. Энэ дээр бол Байнгын хорооны дарга Ганбаатар ямар ч хамаагүй. Хэрвээ сайд ирээгүй бол хэлэлцэх асуудлыг хойшлуулах юм уу яах юм гишүүд яаж шийдэх юм.

Ингээд би горимын санал гаргачихъя. “Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаарх Зам, тээврийн сайдын мэдээллийг холбогдох албан тушаалтнууд ирээгүй учраас хойшлуулж байна. Хойшлуулъя гэсэн ийм горимын саналыг гаргая. Яамныхан нэг юм анхаараарай.

Бид Их Хурлын гишүүд бид өөрсдийгөө хүндлээд байгаа биш шүү. Биднийг сонгосон ард иргэд, бидний энэ ярьж байгаа асуудлыг сонсож байгаа ард иргэдийг хүндэтгэж Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд сайд л мэдээлэл өгнө шүү. Ингээд энэхүү мэдээллийг хойшлуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Бид ингээд дэмжлээ.

Та нарт 1 юм хэлэхэд бид нар аль болохоор үдээс хойш бас хурлуудаа хийгээд байгаа нь Засгийн газрын хуралдааны дараа бас бид хийж байгаа ийм хэлбэр шүү. Тэгээд байнгын хороог хүндэтгэж, дараагийн ээлжид сайдтайгаа ирж оролцоно гэж би найдаж байна.

15.30 цаг.

Ингээд 4 дэх асуудал руугаа оръё.

4 дэх асуудал “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны нөөцийн мэдээллээ сонссон. Энэ 1 сард сонссон усны талаар мэдээлэл Байгаль орчны яамтай хамтарч сонссон шүү. Тэгээд энэ талаар ажлын хэсэг байгуулъя гэдэг хүсэлтийг Ганзориг гишүүн албан бичгээр өгсөн байгаа. Үүнтэй холбогдуулж ажлын хэсгийг нь өнөөдөр баталж ажилд нь оруулъя гэсэн ийм саналын томьёолол байгаа юм байна. Ингээд та бүхэнд би уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны нөөцийн зөв зохистой ашиглалт, усны ашиглах боломжит нөөц, ус хэрэглээний хэтийн төлөв, ус ашигласны болон ус бохирдуулсны үнэ, төлбөр, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ийм ажлын хэсгийг байгуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар дээрх мэдээллийг хэлэлцсэнтэй холбогдуулан үйлдвэрлэлд ашиглаж байгаа гүний болон хөрсний усны зөв, зохистой хэрэглээ, гүний усыг ашиглах боломжит нөөц, үйлдвэрт ашиглаж байгаа усны үнэ, төлбөр, ус хэрэглээний хэтийн төлөвийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулахаар тогтсоны дагуу тогтоолын төслийг боловсруулж та бүхэнд тараасан байгаа.

Ингээд энэ тогтоолын төсөлтэй холбогдуулж ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Ингээд Мөнхбаясгалан гишүүнээр саналыг тасаллаа. Болдын Уянга гишүүн үг хэлнэ.

Б.Уянга: Ажлын хэсэг ийм агуулгатай усны нөөцтэй холбоотой, тэгээд үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа усны шинж чанар дээр нь тогтсон ийм ажлын хэсэг гарч байгаад баяртай байна. Ажлын хэсгийн гишүүнээр орж ажиллах хүсэлтэй байна. Тэрийгээ илэрхийлэх гэсэн юм.

С.Ганбаатар: Уянга гишүүний саналыг хүлээж авлаа. Ингээд Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ, асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Миний сонгогдсон 7 дугаар тойрогт аж үйлдвэрийн зориулалтаар гүний ус хэрэглэдэг хамгийн том компаниуд байдаг учраас энэ ажлын хэсгийг талархалтайгаар хүлээн авч, ажлын хэсэгт орох саналаа илэрхийлж байна.

С.Ганбаатар: Ажлын хэсэгт орж ажиллахаар хэллээ. Ингээд Мөнхбаясгалан гишүүн, Уянга гишүүн, Мөнхтулга гишүүн байна. Өөр гишүүд байвал одоо энэ шинэ ажлын хэсэгт ороод, өмнөх ажлын хэсгүүдээ дүгнэж хэлэх цаг болсон.

Энэ дээр танилцуулж би бас байр сууриа хэлэхэд усны үйлдвэрлэлийн асуудалтай нь холбогдуулж байгаа шүү. Бид яг усны байгаль орчинтой холбоотой асуудлыг нь бид хөндөж аваагүй. Жишээ нь Улаанбаатар хотод Туул гол саяын усны том форум болсон. Энэ дээр бол Туул голын асуудал үнэхээр аюултай байдалд орчихсон байгаа. Үйлдвэрлэлийн хэрэглээгээр үнийг нь төлдөггүй олон асуудлууд байгаа. Ингээд үйлдвэрлэлтэй, бүтээмжтэй холбоотой асуудлыг нь гэдгийг онцолж хэлж байна. Ингээд ямар ч байсан 3 хүн сая даргатайгаа 4.

Тэгвэл Тулга гишүүн, Мөнхтулга 2 микрофонд хэлсэн нь дээр байх. Тулга гишүүний микрофоныг өгье.

Б.Тулга: Байнгын хороодын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье. Тэгэхээр энэ ажлын хэсэг дээр бас ажлын хэсгийн бүрэлдэхүүн сондгой тоотой байх ёстой байх. Тэгээд нэрээ оруулчихъя. Ер нь усны чиглэлээр бас тодорхой ажлуудыг өмнө нь хийж байсан туршлага бий. Монгол Улсын хилийн усны хэлэлцээрийг ахалж ажиллаж байсны хувьд усны хэрэглээ, цаашид ер нь Монгол Улс усаа бас хэрхэн яаж ашиглах вэ, үнэ тариф дээр ямар байгаа гэдгийг энэ ажлын хэсэг дээр орж ажиллая гэсэн саналтай.

С.Ганбаатар: Баярлалаа. Тулга гишүүний туршлага бол үнэхээр энэ дээр бол бидэнд их хэрэгтэй байгаа. Тэгээд энэ усны төлбөр тооцоо, усны үйлдвэрлэлийн хэрэглээний асуудал дээр бол 2013 онд сонсгол, нийтийн сонсгол хийж байсан. Би өөрөө ахалж ажиллаж байсан. Одоо энэ бол маш их ач холбогдолтой байгаа. Ингээд Мөнхтулга гишүүн энэ дээр бас байр сууриа хэлнэ үү.

П.Мөнхтулга: Нөгөө Их хурлын даргын баталсан “Ус ашиглалтын эрх зүйн орчныг сайжруулах” гэсэн Уянга гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгаа. Тэгээд тэнд угаасаа орчихсон ажиллаж байгаа учраас тэгээд яг манай тэр ажлын хэсгийн бас үйлдвэрлэлийн зориулалтаар гэдэг салбар хэсэг нь явж байна. Тэгэхээр давхар ажиллаад явчихъя. Нэгэнт ажиллаж байгаа юм чинь. Тэгээд ажлын хэсэгт орох саналтай байна.

С.Ганбаатар: Ингээд ялангуяа говийн гишүүд Мөнхбаясгалан гишүүн байна, Мөнхтулга гишүүн байна. Одоо яг Тамирын гол эд нар гээд бас ноцтой олон асуудлууд байгаа. Тэр олон амралтын газруудтай ч холбоотой зүйлүүд байдаг. Ингээд энэ дээрээ бас нарийн, найдвартай шийдвэр, гарц гаргалгаа гарна гэж би итгэж байна.

Ингээд 5 гишүүнтэйгээр энэ усны ажлын хэсгийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Батлут гишүүн, Үүрийнтуяа гишүүн 2 дэмжсэн. Протоколд тэмдэглэлээ. Тулга гишүүн бас дэмжсэн. Ингээд гишүүд дэмжсэн байна.

Одоо бас яг энэ ажлын хэсэгтэй холбогдуулаад би Байнгын хорооны даргын хувиар 1 санал хэлэхэд,

1 дүгээрт Байнгын хорооны ажлын алба сайд нарыг оролцуулах талаар байнга хэлнэ шүү. Энэ чинь Байнгын хороог, сонгогчдыг бас хүндэлнэ.

2 дугаарт Байнгын хороонд орсон гишүүд маш их идэвхтэй ажиллаж, энэ дээр бас нарийвчилсан үр дүн гаргана гэдэгт би бас итгэлтэй байгаа. Өмнө нь 5 ажлын хэсэг гарчихсан байгаа. Ингээд удахгүй тайлангуудаа боогоод, дүгнээд тогтоолуудаа гаргана гэж бас итгэлтэй байгаагаа хэлье.

Ингээд өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.38 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ